

2016-03-14

Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 2-р сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2016 оны 2 дугаар сард 254 болсноос 146 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 135 нь ажилгүй иргэд байна. Ажил хайгч иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57 буюу 18.3 хувиар, өмнөх сарынхаас 47 ажил хайгч буюу 15.6 хувиар тус тус буурсан байна. Улсын бүртгэл, Статистикийн газрын иргэний бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 2 дугаар сард 66 эх амаржиж, 67 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхний тоо болон мэндэлсэн хүүхдийн тоо 2 буюу 3.1 хувиар өссөн байна.



II. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 2 дугаар сард 754.1 сая төгрөг, зарлага 1386.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 461.8 сая төгрөг буюу 38.8 хувиар буурч, зарлага 191.2 сая төгрөг буюу 15.9 хувиар өслөө. Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 2 сард 2023 хүнд 195.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 284 хүн буюу 12.3 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 88.5 сая төгрөг буюу 31.1 хувиар тус тус буурсан байна.



III. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 2 сарын байдлаар 59 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 58 үүнээс 32 нь эрэгтэй, 26 нь эмэгтэй, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 8 буюу 11.9 хувиар, хүүхэд 8 буюу 12.1 хувиар тус тус буурсан байна. Он гарсаар 20744 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5052 хүн буюу 32.1 хувиар, 763 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 70 хүн буюу 10.1 хувиар тус тус өссөн байна.



IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 2 сард 29 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 8 хэрэг буюу 21.6 хувиар буурсан байна. Илрээгүй гэмт хэргийн тоо 6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 буюу 25.0 хувиар буурч, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 71.4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 52.9 пунктээр өссөн байна. Гэмт хэргийн улмаас 31 хүн гэмтэж, 4 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 4 буюу 2.0 хувиар буурсан, нас баралт 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм. Хэрэглээний үнийн индекс 2016 оны 2 сард 105.2 болж өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсч, жилийн эцсээс 0.3 хувиар, өмнөх сараас 0.1 хувь буусан үзүүлэлттэй байна.



VI. Орон нутгийн төсөв

2016 оны эхний 2 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 2270.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 2366.6 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 386.4 сая төгрөг буюу 19.5 хувиар өсчээ. Аймгийн төсвийн нийт зарлага 2460.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 1973.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 487.4 сая төгрөгийн хэмнэлттэй байна. 2016 оны эхний 2 сарын байдлаар авлагын үлдэгдэл 20.8 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 441.6 сая төгрөг байна.



VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 2 дугаар сард төллөсөн хээлтэгч 569 байна. Эм ямаа 224, эм хонь 177, үнээ 161, гүү 7 төллөжээ. Гарсан төл 85.1 хувь буюу 484 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 158 толгойгоор их байна. 2016 оны эхний 2 сард том малын зүй бус хорогдол 2453 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2421 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 1 мал байна.



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 2 сард 9060.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3624.2 сая төгрөг буюу 66.7 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 3583.8 сая төг буюу 72.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 9084.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2361.5 сая төгрөг буюу 35.1 хувиар өслөө. Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 8561.6 сая төг буюу 94.2 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.